

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/25/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/226  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн шилжих үлдэгдлийн 466,755.5 мянган төгрөгөөр бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 281,577.7 мянган төгрөгийн ажил хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 29-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 51 зорилт 191 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 90,72%-тай буюу "Үр дүнтэй" гэж дүгнэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Тайлант онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 3,160,926.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 195,898.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

G/Архив/Албан бичиг 2023/ А4

19030293

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,340,213.4</b>	<b>2,050,411.4</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	670,540.0	1,642,455.1
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	377,102.8	309,670.6
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	292,570.6	98,285.7
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		5,604,851.1	2,817,526.4
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	5,604,851.1	2,817,526.4
39200	<b>Биет хөрөнгө</b>		5,502,678.6	2,776,083.2
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	102,172.5	41,443.2
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>6,945,064.5</b>	<b>4,867,937.8</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>23,493.6</b>	<b>12,430.5</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	23,493.6	12,430.5
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	23,493.6	12,430.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>6,921,570.9</b>	<b>4,855,507.3</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>6,921,570.9</b>	<b>4,855,507.3</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,799,159.0	668,984.8
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,799,159.0	668,984.8
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>3,824,293.9</b>	<b>3,985,513.7</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,298,118.1	201,008.8
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>6,945,064.5</b>	<b>4,867,937.8</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>5,215,901.7</b>	<b>3,191,399.1</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>934,453.8</b>	<b>1,659,720.5</b>
110	Орлогын албан татвар		90,857.1	249,408.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		90,857.1	260,260.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-10,852.4
113	Хөрөнгийн албан татвар		2,400.0	18,503.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		841,196.7	1,391,809.2
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	<b>697,682.6</b>	<b>515,691.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого		697,682.6	515,691.4
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>3,583,765.3</b>	<b>1,015,987.2</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>4,993,715.4</b>	<b>1,846,700.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>4,779,640.9</b>	<b>1,282,054.6</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>2,966,417.5</b>	<b>1,241,078.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,241,272.0	347,945.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		164,457.9	44,342.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		349,374.9	378,377.5
2104	Хангамж, бараа материалын зардал		83,231.1	64,694.6
2105	Нормативт зардал		446,713.3	41,805.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,066.5	9,840.0
2107	Томилолт, зочны зардал		5,189.1	4,268.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		57,995.8	5,011.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		604,117.1	344,794.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>1,813,223.4</b>	<b>40,976.1</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>214,074.5</b>	<b>564,645.6</b>
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>222,186.3</b>	<b>1,344,699.0</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>82,123.5</b>	<b>3,357,324.3</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>140,062.8</b>	<b>-2,012,625.3</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,781,508.1	0.0	6,781,508.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,781,508.1	0.0	6,781,508.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	140,062.8	0.0	140,062.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,921,570.9	0.0	6,921,570.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,921,570.9	0.0	6,921,570.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-53,438.3	0.0	-53,438.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,868,132.6	0.0	6,868,132.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-2,012,625.3	0.0	-2,012,625.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,855,507.3	0.0	4,855,507.3

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,617,861.9	2,733,546.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	934,453.8	1,606,822.9
110	Орлогын албан татвар	90,857.1	196,510.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	90,857.1	207,363.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-10,852.4
113	Хөрөнгийн албан татвар	2,400.0	18,503.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	841,196.7	1,391,809.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,917.1	9,131.6
1181	Газрын төлбөр	1,733.7	2,362.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	829,545.8	1,380,315.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,909.2	110,473.6
120	Нийтлэг татварын бус орлого	158,909.2	110,473.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,524,498.9	1,016,249.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,966,271.4	1,012,270.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,966,271.4	1,012,270.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,152,780.1	969,982.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,238,979.6	326,310.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,242.4	40,416.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	349,354.9	382,419.3
2104	Хангамж, бараа материалын зардал	68,019.9	35,760.4
2105	Нормативт зардал	154,854.2	41,812.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,017.9	11,340.0
2107	Томиллолт, зочны зардал	5,189.1	3,572.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,203.9	34,695.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,918.3	93,656.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,813,491.3	42,288.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	651,590.5	1,721,275.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	809,443.4	747,852.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	809,443.4	747,852.1
2200	Дотоод эх үүсвэрээр	809,443.4	747,852.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-809,443.4	-747,852.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-89,130.0	-1,508.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,130.0	1,508.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-246,982.9	971,915.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	917,522.9	670,540.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	670,540.0	1,642,455.1

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,943,407.6</b>	<b>1,674,177.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,004,679.7</b>	<b>924,816.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>968,993.5</b>	<b>889,130.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>345,451.8</b>	<b>326,310.1</b>
210101	Үндсэн цалин	275,364.4	263,791.4
210102	Нэмэгдэл	65,078.9	48,668.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21.0
210104	Урамшуулал	5,008.5	6,732.9
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,096.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,118.3</b>	<b>40,416.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,299.8	27,989.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,454.7	3,258.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,763.8	2,529.6
210204	Ажилгүйдлийн даатгал	691.0	597.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,909.0	6,041.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>385,864.9</b>	<b>369,425.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	42,500.8	31,170.1
210302	Түлш, халаалт	340,475.2	336,094.1
210303	Цэвэр, бохир ус	2,888.9	2,161.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,950.6</b>	<b>33,882.1</b>
210401	Бичиг хэрэг	2,111.4	2,059.8
210402	Тээвэр, шатахуун	24,343.5	24,331.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,295.7	4,291.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200.0	3,200.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,400.0</b>	<b>11,340.0</b>
210604	Урсгал засвар	11,400.0	11,340.0
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>3,774.5</b>	<b>3,572.2</b>
210702	Дотоод албан томиллолт	3,774.5	3,572.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>47,356.9</b>	<b>34,395.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,813.3	32,420.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	812.3	812.0
210803	Даатгалын үйлчилгээ	792.2	475.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	472.6	472.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	466.5	214.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>95,076.5</b>	<b>69,789.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,076.5	66,789.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0	3,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,686.2</b>	<b>35,686.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,686.2</b>	<b>35,686.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,686.2	33,686.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0	1,999.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>836,727.9</b>	<b>747,852.1</b>
220001	Барилга байгууламж	365,095.5	343,367.7
221001	Их засвар	387,092.2	362,324.0
223001	Бусад хөрөнгө	84,540.2	42,160.4
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>102,000.0</b>	<b>1,508.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	102,000.0	1,508.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,943,407.6</b>	<b>1,763,019.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>269,817.7</b>	<b>269,817.7</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	269,817.7	269,817.7
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,023,179.8</b>	<b>1,436,290.6</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,023,179.8	1,436,290.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>650,410.1</b>	<b>56,911.5</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,000.0	56,911.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	548,410.1	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	44,153.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	132,258.6
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>42</b>	<b>42</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>106</b>	<b>106</b>
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57
620003	Үйлчлэх ажилтан	31	31
620004	Гэрээт ажилтан	7	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>106</b>	<b>106</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16	16
650004	СББ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17	17
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21	21
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	37	37
650010	Гэрээт ажилтан	7	7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	гүйцэтэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>218,949.8</b>	<b>76,010.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,949.8</b>	<b>76,010.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>188,472.1</b>	<b>38,362.0</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,762.5</b>	<b>12,654.1</b>
210303	Цэвэр, бохир ус	9,762.5	12,654.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>615.0</b>	<b>1,878.3</b>
210401	Бичиг хэрэг	615.0	1,000.0
210402	Тээвэр, шатахуун	-	777.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	100.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78,072.8</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,754.9	-
210502	Хоол, хүнс	317.9	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000.0</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	5,000.0	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>38.1</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	38.1	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,916.0</b>	<b>300.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,916.0	300.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,067.7</b>	<b>23,529.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,963.7	23,529.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,477.7</b>	<b>37,648.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,575.2</b>	<b>5,340.1</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,067.2	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,508.0	5,340.1
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>19,902.5</b>	<b>32,308.2</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	19,902.5	31,783.7
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	524.5
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>276,777.5</b>	<b>75,748.1</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>276,777.5</b>	<b>75,748.1</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	251,473.5	28,667.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,304.0	47,080.3
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>262.3</b>	<b>262.3</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	262.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	262.3	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн шилжих үлдэгдлээр 229,095.5 мянган төгрөгөөр үерийн далан, 2,000.0 мянган төгрөгөөр Батсүмбэр толгойн Сүхбаатарын хөшөө, 45,000.0 мянган төгрөгөөр өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих бага оврын трактор, 74,660.0 мянган төгрөгөөр бохир соруулах машин, 20,000.0 мянган төгрөгөөр хуучин Соёлын төвийн дотор засвар, 83,000.0 төгрөгөөр цэцэрлэгт хүрээлэнгийн өргөтгөл, 13,000.0 мянган төгрөгөөр Монгол бичгийн өргөө зэрэг бүтээн байгуулалтыг хийж ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,000.0 мянган төгрөгөөр орон нутаг судал танхим, 151,627.8 мянган төгрөгөөр дэд станц, 68,973.6 мянган төгрөгөөр Тэрэлж голын гүүрнээс Гангын үзүүр хүртэл сайжруулсан зам хоолой, 10,520.5 мянган төгрөгөөр цамхагт гэрэл, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 10,545.2 мянган төгрөгөөр Хэрлэн голын таван салааны гүүр засварласан, 15,110.6 мянган төгрөгөөр мод тарьж ногоон байгууламж, 14,800.0 мянган төгрөгөөр ойн сэргээн ургалтад туслах ажил 20 га-д хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 29-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 51 зорилт 191 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 90,72%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-ны, 2022 оны 7 дугаар сарын 01-ны, 2022 оны 8 дугаар сарын 29-ны, 2022 оны 12 дугаар сарын 9-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/193 захирамжаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна. Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналтаас төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтад 2022 оны 3 дугаар сарын 11-нд хяналт шалгалт хийж 17 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, тайланг хүргүүлж ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/22 тоот захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,077,126.8 мянган төгрөгөөр буюу 29,9 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	670,540.0	1,642,455.1	971,915.1
Авлага	377,102.8	309,670.6	-67,432.3
Бараа материал	292,570.6	98,285.6	-194,285.0
Үндсэн хөрөнгө	5,604,851.1	2,817,526.4	-2,787,324.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,945,064.5</b>	<b>4,867,937.7</b>	<b>-2,077,126.8</b>
Өр төлбөр	23,493.6	12,430.4	-11,063.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,921,570.9	4,855,507.3	-2,066,063.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,945,064.5</b>	<b>4,867,937.7</b>	<b>-2,077,126.8</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 971,915.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,642,455.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд орон нутгийн орлого 1,505,467.3 мянган төгрөг нь давсан орлогын үлдэгдэл, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 63,569.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сан 68,689.0 мянган төгрөг нь

шалгаруулалтад тэнцсэн төслийн материал ирүүлээгүй үлдэгдэл, 4,729.2 мянган төгрөгийн эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 309,670.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 67,423.3 мянган төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газар 8,000.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 90.9 мянган төгрөг, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв 62,288.3 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 98,285.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 194,285.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 195,898.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,817,526.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,787,324.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 3,160,926.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 23,493.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 12,430.4 мянган төгрөг болж 11,063.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн дуусгаагүй ажлын өглөг 7,328.0 мянган төгрөг, шилжих үлдэгдлээр хийсэн хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл 4,653.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 449.3 мянган төгрөгийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 4,855,507.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,066,063.6 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,012,625.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,642,455.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 971,915.1 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>			
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>670,540.0</b>	<b>1,642,455.1</b>	<b>971,915.1</b>
<b>Төгрөг</b>	<b>670,540.0</b>	<b>1,642,455.1</b>	<b>971,915.1</b>
Төрийн сангийн харилцах	658,570.1	1,637,725.9	979,155.8
Арилжааны банк дахь харилцах	11,969.8	4,729.2	-7,240.6
<b>Дүн</b>	<b>670,540.0</b>	<b>1,642,455.1</b>	<b>971,915.1</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 1,642,455.1 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 1,637,725.9 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 4,729.2 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 1,642,455.1 мянган төгрөгийн 91,6 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 1,505,467.3 мянган төгрөг, 3,9 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 63,569.5 мянган төгрөг, 4,2 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 68,689.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 0,3 хувь буюу 4,729.2 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 979,155.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 891,312.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 33,439.5 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 55,403.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 7,240.6 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн зарим ажлуудын /гэрэлтүүлгийн цахилгааны урсгал засвар, Өжөөний гүүрний хажууд далан тавих, Байдлагийн жижиг голын гүүр засах/ санхүүжилтийг олгохдоо ХХОАТ гэж 10 хувь буюу 654.0 мянган төгрөгийн суутган татварын албанд шилжүүлсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийг зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 309,670.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 67,431.9 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	70,379.2	6,960.9	-63,418.3
Хувь хүмүүсээс авах авлага	306,723.6	302,709.7	-4,013.9
<b>Дүн</b>	<b>377,102.8</b>	<b>309,670.6</b>	<b>-67,431.9</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга тайлан

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 302,709.7 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 97,7 хувийг, байгууллагаас авах орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын дутуу ажлын авлага 6,960.9 мянган төгрөг буюу 2.3 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 309,670.6 мянган төгрөгийн 97,7 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 2,3 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 98,285.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 194,315.0 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>86,763.5</b>	<b>22,053.9</b>	<b>-64,709.6</b>
Тусгай зориулалттай материал	86,763.5	22,053.9	-64,709.6
Дуусаагүй үйлдвэрлэл	10,000.0		-10,000.0
<b>Хангамжийн материал</b>	<b>188,307.1</b>	<b>63,731.7</b>	<b>-124,575.4</b>
Бичиг хэргийн материал	25,516.3	5,907.4	-19,608.9
Аж ахуйн материал	151,972.7	46,397.4	-105,575.3
Сэлбэг хэрэгсэл		850.0	850.0
Түлш, шатах тослох материал	5,587.6	1,895.7	-3,691.9
Хүнсний материал	802.5		-802.5
Бусад хангамжийн материал	4,458.0	8,681.2	4,223.2
<b>Мал амьтад</b>	<b>7,500.0</b>	<b>12,500.0</b>	<b>5,000.0</b>
<b>Дүн</b>	<b>292,600.6</b>	<b>98,285.6</b>	<b>-194,315.0</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга тайлан

Бараа материалын үлдэгдэл 98,285.6 мянган төгрөгийн 72,8 хувь буюу 71,526.6 мянган төгрөгийг Засаг даргын тамгын газар, Ойн ангийн 28.0 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5,067.1 мянган төгрөг буюу 5,2 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 21,663.9 мянган төгрөг буюу 22,0 хувийг бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 148,135.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй 5,450.0 мянган төгрөг нийт 153,585.6 мянган төгрөгөөр нэмэгдэж шилжүүлсэн 10,000.0 мянган төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 195,898.1 мянган төгрөг, зарцуулсан 141,972.5 мянган төгрөг нийт 347,870.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,817,526.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,787,324.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>5,502,678.7</b>	<b>2,776,083.3</b>	<b>-2,726,595.4</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,812,754.3	1,005,857.0	-2,806,897.3
Авто-тээврийн хэрэгсэл	304,748.0	442,105.6	137,357.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	248,360.6	60,082.0	-188,278.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	105,980.8	25,054.8	-80,926.0
Бусад үндсэн хөрөнгө	614,935.7	576,505.2	-38,430.5
Дуусаагүй барилга, байгууламж	260,000.0	15,110.6	-244,889.4
Зам гүүрний байгууламж	137,726.8	651,368.1	513,641.3
Номын фонд	18,172.4		-18,172.4
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>102,172.5</b>	<b>41,443.2</b>	<b>-60,729.3</b>
Программ хангамж	1,474.3	515.0	-959.3
Бусад биет бус хөрөнгө	100,698.2	40,928.2	-59,770.0
<b>Дүн</b>	<b>5,604,851.1</b>	<b>2,817,526.4</b>	<b>-2,787,324.7</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,5 хувь буюу 2,804,592.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,1 хувь буюу 2,938.7 мянган төгрөгийг ИТХ, 0,35 хувь буюу 9,660.8 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 0,05 хувь буюу 334.0 мянган төгрөгийн хөрөнгийг Ойн анги эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 4,131,510.6 мянган төгрөг болж, худалдан авсан 223,552.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан 458,095.5 мянган төгрөг, бусад 249,312.3 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 90,843.0 мянган төгрөг, шилжүүлсэн 273,000.0 мянган төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 3,160,926.8 мянган төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн 1,052,747.9 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 423,520.4 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 587,005.0 мянган төгрөгийн, Соёлын төвийн 1,097,653.4 мянган төгрөгийн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12,430.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,062.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	3,419.9	42.5	-3,377.4
Байгууллагад төлөх өглөг	19,624.2	7,777.4	-11,846.8
Хувь хүмүүст төлөх өглөг	449.3	4,610.6	4,161.3
<b>Дүн</b>	<b>23,493.4</b>	<b>12,430.5</b>	<b>-11,062.9</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Орон нутгийн хөгжлийн сангийн 7,328.0 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 4,653.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 449.4 мянган төгрөг нийт 12,430.5 мянган төгрөгийн өглөг байна. Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 12,430.5 мянган төгрөг болж, 11,062.9 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь Засаг даргын тамгын газар 4,381.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 9,790.7 мянган төгрөг, эмийн эргэлтийн сангийн өглөг 4,219.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,855,507.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,066,063.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,799,158.9	668,984.8	-1,130,174.1
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,824,293.9</b>	<b>3,985,513.7</b>	<b>161,219.8</b>
Өмнөх үеийн үр дүн	3,684,231.1	5,998,139.0	2,313,907.9
Тайлант үеийн үр дүн	140,062.8	-2,012,625.3	-2,152,688.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,298,118.1	201,008.8	-1,097,109.3
<b>Дүн</b>	<b>6,921,570.9</b>	<b>4,855,507.3</b>	<b>-2,066,063.6</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,855,507.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,066,036.3 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр Засгийн газрын сан 1,130,174.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 1,097,109.3 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,313,907.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 2,152,688.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,573,960.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 314,093.7 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,888,054.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 18,500.0 мянган төгрөгөөр, Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 70,696.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолд зааснаар Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд 332,593.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 807,928.8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 269,817.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 30,130.2 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдлийг 518,279.9 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 102,000.0 мянган төгрөгөөр нийт 2,060,750.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2022 оны орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх малын тоо толгойн албан татвар нэмэгдүүлж, төсвийн урсгал зардал ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны зардал, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолд зааснаар Мөнгөнморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 332,593.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр хэвээр баталж гүйцэтгэлээр 1,652,269.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 3,6 дахин биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого 3,721.1 мянган төгрөгөөр суутган-1, 8,473.8 мянган төгрөгөөр суутган-2, хадгаламжийн хүүгийн орлого 10,594.3 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 754.3 мянган төгрөгөөр, бууны албан татвар 540.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 368.4 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр 1,998.0 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 1,150.0 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 4,516.5 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 15,637.5 мянган төгрөг нийт 47,754.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 117,342.7 мянган төгрөгөөр бууруулан 1,943,407.6 мянган төгрөгөөр тодотгон, 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 02 дугаар тогтоолоор шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 332,593.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 690,586.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 269,817.1 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 548,410.1 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 102,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,961,444.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 100,652.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,674,176.9 мянган төгрөг буюу 86,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 269,230.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зардал 100,492.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь санхүүжүүлэх орлогын эх үүсвэр дутуу бүрдсэн, шаардлага хангасан төсөл хөтөлбөр ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, 26 арга хэмжээнд 836,727.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 747,852.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	65,209.1	61,967.5	3,241.6	95.0
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	1,016,049.4	940,987.4	75,062.0	92.6
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	196,353.4	191,166.1	5,187.3	97.4
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	43,385.9	38,587.8	4,798.1	88.9
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	99,439.1	97,985.3	1,453.8	98.5
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	38,227.0	32,199.3	6,027.7	84.2
7	Ойн анги- үндсэн үйл ажиллагааны зардал	64,295.7	59,413.6	4,882.1	92.4
8	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	102,000.0	1,508.0	100,492.0	1.5
9	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	318,447.9	250,361.8	68,086.2	78.6
	<b>Дүн</b>	<b>1,943,407.6</b>	<b>1,674,176.8</b>	<b>269,230.8</b>	<b>86.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 28,667.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 47,080.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн урьд оны үлдэгдэл 262.2 мянган төгрөг нийт 75,748.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 43,702.1 мянган төгрөг зарцуулж, 32,308.2 мянган төгрөг буюу Засаг даргын тамгын газар 31,783.7 мянган төгрөг орон нутгийн төсөвт, Эрүүл мэндийн төвийн 524.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 100%	65,209.1	61,967.5
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92,6%	1,016,049.4	940,987.3
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100% Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн материал ирүүлээгүй байна.	102,000.0	1,508.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 9 зорилт 31 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Сургуульд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ аймгийн дунджаас 2% илүү, “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 72.1%, “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын 3-н дэд хөтөлбөрийн биелэлт 99,6%, “Оюунлаг Мөнгөнморьт” хөтөлбөрийн хэрэгжилт 95.3%.	196,353.4	191,166.1
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 14 зорилт 51 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98 %	43,385.9	38,587.8
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 7 зорилт 36 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 91%	99,439.1	97,985.3
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 10 төрлийн үзлэгт 5000 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд иргэдийг бүрэн хамруулна.	Нийт 10 төрлийн үзлэгт 5857 хүн, хамрагдаж Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээний чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 86,9%, элэгний хавдрын эрт илрүүлэг 86,9%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 92.3%, умайн хүзүүний эрт илрүүлэг 75% нийт хэрэгжилт 87.7%.	38,227.0	32,199.3
8	71403-Ойн анги	2022.01.01 2022.12.31	Ойн анги нь 4 зорилт 25 арга хэмжээ	Хэрэгжилт 87%	64,295.7	59,413.6
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 3 төсөл, шинээр хэрэгжих 6 төслийг 318,447.9 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9, хэрэгжээгүй 1 хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 88%	318,447.9	250,361.8

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Хоршоо хөгжүүлэх сангийн хөтөлбөр хэрэгжээгүй нь 45,088.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүй, шалгаруулалтад тэнцсэн төслийн материал ирүүлээгүйгээс шалтгаалжээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр 88% хэрэгжсэн нь тендер зарласан ч оролцогч байхгүй, ойн анги хөтөлбөр 87%-тай хэрэгжсэн нь ой модноос үр түүх ажил цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалаад үр унаж усны үерт урснаас шалтгаалжээ.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 05/19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 1,840,407.6 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 27,621.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20,715.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин хөлс, НДШ-ийн зардал 24,843.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 16,439.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 68.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 60.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 202.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 12,961.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 25,287.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 3.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 88,875.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийцлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 96,4 хувь, 5,0 саяас дээших орлогын 6 гүйлгээ, зарлагын 32 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 8 шийдвэр, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 50 мэдээлэл байршуулахаас 304,340.0 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ байршуулаагүй байна.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар газар худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой 1 төлбөрийн акт, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 1 албан шаардлага, дотоод хяналт, орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 05/94 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	203.8	1	203.8	100
Албан шаардлага	1	27,807.6	1	27,807.6	100
Зөвлөмж	2	86,088.2	2	86,088.2	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>114,099.6</b>	<b>4</b>	<b>114,099.6</b>	<b>100</b>

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 327,992.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 327,922.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: 1.Тус байгууллага тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгийн зардалд 250,728.9 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үнэ төлбөргүй гарсан зардалд үндсэн хөрөнгө 65,691.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд үнэ төлбөргүй гарсан зардалд бараа материал 11,571.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 361,254.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,483.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 357,770.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

1.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд зарцуулаагүй үлдэгдэл 3,483.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 3 нэр төрлийн орлогыг 3,602.8 мянган төгрөг, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 2,073.9 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 9 нэр төрлийн орлогыг 47,754.0 мянган төгрөгөөр нийт 53,430.7 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансны цахим тендерт худалдан авах ажиллагаатай холбоотой 304,340.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 3 гүйлгээ байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Ойн анги	1	1			1			
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>		<b>2</b>			

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	327,992.0			3	327,992.0	3	327,992.0		
ЗДТГ	3	789,185.3	3	789,185.3			3	789,185.3		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>1,117,177.3</b>	<b>3</b>	<b>789,185.3</b>	<b>3</b>	<b>327,992.0</b>	<b>6</b>	<b>1,117,177.3</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	56,914.6	1	3,483.9			1	53,430.7
ЗДТГ	2	14,985.9	2	14,985.9				
Орон нутгийн хөгжлийн сан	1	654.0					1	654.0
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>97,315.2</b>	<b>3</b>	<b>18,952.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>78,363.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	304,340.0					1	304,340.0
ЗДТГ	1	633,917.9					1	633,917.9
Сум дундын ойн анги	1	261.7					1	261.7
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>938,519.6</b>	<b>0</b>	<b>0</b>			<b>3</b>	<b>938,519.6</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>938,519.6</b>	<b>0</b>	<b>0</b>			<b>3</b>	<b>938,519.6</b>